

Газар эзэмших эрхийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 60 дугаар зүйлийн 60.1.2, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус дүүргийн Газрын албанаас ирүүлсэн саналыг харгалзан 19 дүгээр хороо, Гүнтийн зусланд 2012 оны А/244 дүгээр захирамжаар Жагдагдагвын Мөнхнаран, Зоригтын Уранцэцэг нарт газар эзэмшүүлсэн байршилд 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/245 дугаар захирамжаар Цэдэвийн Амартогтоход давхардуулан эзэмшүүлсэн байх тул 2014 оны А/245 дугаар захирамжийн Цэдэвийн Амартогтоход холбогдох хэсгийг бүхэлд нь хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Цэдэвийн Амартогтохоос газар эзэмших эрхийн нэр шилжүүлсэн 2015 оны А/645 дугаар захирамжийн Балжмаагийн Алтанзаяа, Ганбаатарын Дүүрэнбаяр, Цэдэвийн Алтангэрэл, Эрдэнэбулганы Баясгалан нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь хүчингүй болсон иргэдтэй байгуулсан газар эзэмших эрхийг цуцалж гэрчилгээг хураан авч, газрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ